

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН  
ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХАМААРАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023.12.05

Мөнхбулаг

№	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6
<b>Зорилт: Нэг. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</b>					
1	1.1 Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фейсбүүк, твиттер, инстаграм youTube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх.	Түгээсэн мэдээлэл, иргэдийн хандалтын тоо, Харьяа газар нэгжийг хамруулсан тоо		Албан байгууллагуудын мэдээллийн самбар болон цахим хуудсуудаар Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн гарын авлага, шторк, мэдээ мэдээллийг бэлтгэн байршуулан иргэдэд сурталчлан ажиллаж байна. Мөн <a href="http://esunzuil.ov.gov.mn/">http://esunzuil.ov.gov.mn/</a> веб сайтад мэдээллийг байршуулан ажиллаж байна.	100
2	1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах.	Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан тоо		Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Есөнзүйл суманд хамаарах арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөг баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100

3	1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Ил тод байдлын” мэдээллийн самбар ажиллуулах.	Шинэчилсэн мэдээллийн тоогоор		Засаг даргын Тамгын газарт Ил тод байдлын самбар байршуулан мэдээллийг тухай бүр шинэчлэн иргэдэд мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. Мөн төсвийн ил тод байдлын самар байршуулан мэдээллийг тухай бүр шинэчлэн төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. <a href="https://www.facebook.com/esunzuil.zdtgazar">https://www.facebook.com/esunzuil.zdtgazar</a> гэсэн цахим хаягаар иргэдэд мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. 2023 онд <a href="https://shilendans.gov.mn/">https://shilendans.gov.mn/</a> сайтад мэдээллийг бүрэн оруулаад байна.	100
4	1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.	Боловсруулсан матеариал, бэлтгэсэн нийтлэл нэвтрүүлгийн тоо	250000	Тухайн онд иргэдэд мэдээ, тайланг түргэн шуурхай хүргэх зорилгоор <a href="http://esunzuil.ov.gov.mn/">http://esunzuil.ov.gov.mn/</a> веб сайт болон <a href="https://www.facebook.com/esunzuil.zdtgazar">https://www.facebook.com/esunzuil.zdtgazar</a> , Зар Есөнзүйл сум, <a href="https://www.facebook.com/groups/esonzuil">https://www.facebook.com/groups/esonzuil</a> Есөнзүйл сумын нэгдсэн групп, Есөнзүйл онцгой комисс гэсэн цахим хаягуудаар мэдээллийг иргэдэд түгээн ажиллаж байна.	100
<b>Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах</b>					
5	2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо		Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдаас урьдчилан мэдүүлгийг авч хууль тогтоомжийн хүрээнд хянуулан албан тушаалт томилж хэвшээд байна. Мөн шинээр томилогдон ажиллаж байгаа албан	100

				хаагч бүрд сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил, авлига албан тушаалын гэмт хэргээс ангид байх талаар тухай бүр зөвлөмж өгөн ажиллаж байна.	
6	2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.	Хамтран ажилласан байгууллага, арга хэмжээний тоо		Албан тушаалтныг үйл ажиллагаандаа авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар зөвлөгөө өгөн болзошгүй тохиолдолд мэдэгдэл тайлбар гаргуулан авч зөрчил дутагдал гаргалгүй ажиллаж байна.	100
<b>Зорилт 3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох</b>					
7	3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.	Авлигаас урьдчилан сэргийлэх заалт тусгасан гэрээний тоо		Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан тушаалын гэмт хэргээс хол байх, авлигын зөрчил гаргалгүй ажиллах талаар тодорхой заалт тусган оруулж хэрэгжилтийг нь жил бүр тооцон зөрчилгүй ажиллаж байна.	100

<b>Зорилт 4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах.</b>					
8	4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	Цахимжуулсан үйлчилгээ, зохион байгуулсан арга хэмжээний тоо		Байгууллагын цахим хуудсанд төрийн байгууллагаас цахимаар үзүүлэх үйлчилгээг ил тод байршуулан сурталчилсан ажиллаж байна. <a href="http://esunzuil.ov.gov.mn/post/134472">http://esunzuil.ov.gov.mn/post/134472</a>	100
9	4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх.	Хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулсан тоо		Засаг даргын Тамгын газрын хувьд 2023 онд орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтын тухай иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэн ажилласан байна. <a href="https://cdn.greensoft.mn/uploads/users/3291/files/%D0%98%D0%A2%D0%A5.pdf">https://cdn.greensoft.mn/uploads/users/3291/files/%D0%98%D0%A2%D0%A5.pdf</a>	100
10	4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо		Сумын хүн малын тооллогын арга хэмжээний үеэр сумын нийт өрх бүрээс санал асуулгын аргаар иргэдээс төрийн байгууллага, албан хаагчдын ажлын талаар үнэлгээ аван үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна.	100
<b>Зорилт 5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх</b>					

11	5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах.	Төлөвлөгөө болон тайлан боловсруулж, танилцуулснаар		Авлигатай тэмцэх сумын төлөвлөгөө биелэлтийг нь албан хаагч нарт танилцуулан хэрэгжилтийн байдлыг цахим хуудсан байршуулан иргэдэд мэдээлэн ажиллаж байна.	100
12	5.2. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусган, хэрэгжүүлэх.	Хэрэгжүүлсэн арга хэмжээ		Байгууллагын дотоод журмыг 2023 онд шинэчлэн баталж хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.	100
<b>Зорилт 6. Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах.</b>					
13	6.1. Эрүүгийн хуулийн авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбогдох зүйл заалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан, удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад сургалт, мэдээлэл өгөх, дээд шатнаас зохион байгуулж буй сургалтад хамруулах	Зохион байгуулсан сургалт, хүргүүлсэн зөвлөмжөөр		Албан байгууллагын дарга, эрхлэгч болон албан хаагч нарыг дээд байгууллагаас зохион байгуулсан сургалт семинарт 2023 онд өссөн дүнгээр 166 албан хаагч хамрагдан мэдлэг мэдээлэл олж аван албан ажилдаа ашиглан ажиллаж байна.	100
14	6.2. Эрсдэл бүхий зарим төрийн байгууллагыг сонгон авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах чиглэлээр тусгайлан нөлөөллийн	Зохион байгуулсан арга хэмжээний тоо		Албан байгууллагын дарга эрхлэгч нарт жил бүр хөрөнгө орлогын мэдүүлэг хэрхэн гаргах болон авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар сургалтыг орж хэвшээд байна.	100

	арга хэмжээг зохион байгуулах.			
15	6.3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжид заасан хориглолт хязгаарлалт зөрчсөн томилгоо, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө, орлогын мэдүүлгийн хугацаанд хяналт, шалгалт явуулах, илэрсэн зөрчлийг арилгах.	Хяналт шалгалтын тоогоор	Сумын Засаг даргын Тамгын газрын хувьд 2023 онд ковидын хууль тогтоомжийн хүрээнд түр томилгоотой ажиллаж байсан 3 албан хаагчийг ажлаас чөлөөлж хууль тогтоомжийн хүрээнд албан хаагчийг толилох шийдвэр гарган ажиллаж байна. Хууль тогтоомжийн хүрээнд урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хянуулан ажиллаж байна.	100
16	6.4. Авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тухай бүр хийж байх.	Сургалтад хамрагдсан иргэн, хүүхэд залуучуудын тоо	Тухайн онд иргэдэд мэдээ, тайланг түргэн шуурхай хүргэх зорилгоор <a href="http://esunzuil.ov.gov.mn/">http://esunzuil.ov.gov.mn/</a> веб сайт болон <a href="https://www.facebook.com/esunzuil.zdtgazar">https://www.facebook.com/esunzuil.zdtgazar</a> , Зар Есөнзүйл сум, <a href="https://www.facebook.com/groups/esonzuil">https://www.facebook.com/groups/esonzuil</a> Есөнзүйл сумын нэгдсэн групп, Есөнзүйл онцгой комисс гэсэн цахим хаягуудаар мэдээллийг иргэдэд түгээн ажиллаж байна.	100
<b>ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ</b>				100

ХЯНАСАН, ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА  Т.БАТ-ӨЛЗИЙ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА  С.БАТ-ЭРДЭНЭ

᠋ H3A0001 9045899